



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2020 оны 02 сарын 03 өдөр

Дугаар 138

Улаанбаатар хот


Шинэ коронавирусын халдвараас
урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг
хангах ажил зохион байгуулах тухай


Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 10 дугаар зүйлийн 10.1.1, 34 дүгээр бүлгийн 34.1.2, 34.2.1, 34.2.6, Монгол улсын Засгийн газрын 2020 оны 30 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/108 дугаар захирамж, Нийслэлийн онцгой комиссын 2020 оны 02 дугаар хурлын тэмдэглэл, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Томуу, томуу төст өвчний өвчлөл, тархалт болон шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөг 1 дүгээр, ажилтан, албан хаагчдыг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, биеийн эсэргүүцэл, дархлааг дэмжих эм бэлдмэлээр хангах зардлын төсвийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Дээрх төлөвлөгөөны биелэлтийг хангаж, хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтэс /Э.Энхцэцэг/-т даалгасугай.

3. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажилд шаардагдах 452.650 /дөрвөн зуун тавин хоёр мянга зургаан зуун тавин/ төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардлаас гаргахын Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
 2020 оны 01 сарын 27 ний өдрийн
 27/28 тушаалын дүгээр хавсралт



ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧНИЙ ӨВЧЛӨЛ, ТАРХАЛТ
 БОЛОН ШИНЭ КОРОНАВИРУСТ ХАЛДВАРААС
 УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ
 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах хэлтэс, ажилтан	Тайлбар
1	2	3	4	5
1	Амьсгалын замын шинэ коронавируст халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж батлуулах	2020.01.27	Архивын эрхлэгч	
2	Томуу, томуу төст өвчин, амьсгалын замын хүнд хэлбэрийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар мэргэжлийн байгууллагуудаас гаргасан заавар зөвлөмжийг албаны болон харьяа байгууллагуудын ажилтан, албан хаагчид, үйлчлүүлж буй иргэд, олон нийтэд тогтмол танилцуулж, сурталчлах	2020.01.27 2020.03.02	Олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн, Мэдээллийн технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн	www.ubservice.gov.mn , facebook, twitter, коридорт байрладаг телевизээр дамжуулан хүргэнэ.
3	Ажилтан, албан хаагчдыг амны хаалт зүүлж, гарын ариун цэвэр сайтар хангаж ажиллахыг анхааруулах, хяналт тавих	2020.01.27 2020.03.02	Ахлах мэргэжилтэн нар	
4	Тус албаар үйлчлүүлж буй иргэдийг амны хаалт зүүхийг анхааруулах, маск зүүгээгүй хүмүүст үйлчлэхгүй байх	2020.01.27 2020.03.02	Нийт ажилтан, албан хаагч	
5	Хорио цээрийн хугацаанд олон нийтийг хамарсан сургалт, спорт, аялал зугаалга, урлаг соёлын арга хэмжээ зохион байгуулах ажлыг түр хугацаагаар хойшлуулах	2020.01.27 2020.03.02	Хэлтэс тус бүр	
6	Ажилтан, албан хаагчдыг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор биеийн эсэргүүцэл, дархлааг дэмжих эм бэлдмэл, гарын эрүүл ахуй болон өрөө, тасалгааны ариутгалын бодисоор хангах	2020.01.28 2020.03.02	ЗУСХ	
7	Албаны эмийн санг шаардлагатай эм, бэлдмэлээр хангах,	2020.01.28 2020.02.18	ЗУСХ	

1	2	3	4	5
8	Ажлын байр, ариун цэврийн өрөө, тасалгаа, хаалганы бариул, цонхыг хлор агуулсан халдваргүйжүүлэх бодисоор тогтмол цэвэрлүүлэх	Тогтмол хугацаанд	ЗУСХ	
9	Монгол улсын Засгийн газрын 2020 оны 30 дугаар тогтоолын дагуу амьсгалын замын цочмог халдвар, томуу, томуу төст өвчнөөр өвчилсөн 5 хүртэлх насны хүүхдээ эмнэлэгт, эсвэл гэрээр асарсан ажилтан, албан хаагчдад 5 хүртэлх хоногийн цалинтай чөлөө олгох	Тухайн үед	ЗУСХ	
10	Худалдаа, үйлчилгээний газруудын ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийлгэх, ажилтан, албан хаагчдыг амны хаалтыг тогтмол хэрэглэж хэвшүүлэх, дотоод хяналтыг сайжруулах талаар зөвлөмж хүргүүлэх, дүүргүүдтэй хамтран, хяналт тавьж ажиллах	2020.01.28 2020.03.02	ХҮХҮХ	
11	Дүүргүүдийн хүнсээр хангах мэргэжлийн ангиудын хүнсний хангамжийн нэгдсэн судалгаа гаргах, нөөц бүрдүүлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хяналт тавьж, тайлагнаж ажиллах	2020.01.31 2020.02.15	ХҮХҮХ	
12	Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/108 дугаар захирамжаар ресторан, баар, кафены ажиллах цагийн хуваарь өөрчлөгдөж 00:00 цаг хүртэл ажиллахаар болсонтой холбогдуулан холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран хяналт тавьж ажиллах	2020.01.31 2020.03.02	ХҮХҮХ	
13	Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч Аж ахуй нэгж байгууллагууд, нийтийн авто тээврийн хэрэгслийн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийх ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангаж, хяналт тавьж ажиллах	2020.01.27 2020.03.02	ДХХ	
14	Төлөвлөгөөний дагуу хийгдсэн ажлын биелэлтийг тогтмол хугацаанд гаргаж, танилцуулах	Тогтмол хугацаанд	Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн	

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2020 оны 02 сарын 21-ний өдрийн
... тушаалын ... дугаар хавсралт



Ажилтан, албан хаагчдыг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх,
биеийн эсэргүүцэл, дархлааг дэмжих эм бэлдмэлээр
хангах зардлын төсөв

№	Бараа, материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	2	3	4	5	6
1	Аньс, нэрс жимсний өтгөрүүлсэн шүүс	2 сар х 23 ш	46	5400	248400
2	Анхны тусламжид шаардагдах эм, бэлдмэл				24250
3	Гар ариутгагч шингэн	литр	5	22000	110000
4	Шингэн сав хийдэг сав	ш	2	35000	70000
	НИИТ				452650